



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 244

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.2, 6.4.6 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, 5 нэрийн, нийт 2,101,927,000.00 (хоёр тэрбум нэг зуун нэгэн сая есөн зуун хорин долоон мянга) төгрөгийн балансын үнэ, 17,455,316.38 (арван долоон сая дөрвөн зуун тавин таван мянга гурван зуун арван зургаан төгрөг гучин найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий түр барилгуудыг данс бүртгэлээс хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хавсралтад заасан (данснаас хассан) түр барилгуудыг буулгах, нүүлгэн шилжүүлэх, засаж сэлбэн, угсарч суурилуулах, шинэчилж сайжруулах ажлыг зохион байгуулж, холбогдох зардлыг нэмж тусган, данс бүртгэлд тусгахыг "Тавантолгой түлш" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ц.Даваацэрэн, "Монголросцветмет" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбат нарт зөвшөөрсүгэй.

3. Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, "Тавантолгой түлш" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ц.Даваацэрэн, "Монголросцветмет" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг хүлээлцэх, зөөж тээвэрлэх, газрыг цэвэрлэж, нөхөн сэргээх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай,

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001149  
14-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 05. дугаар сарын 16.-ны өдрийн  
244. Дугаар тогтоолын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ДАНСНААС ХАСЧ, ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИД ХУЛГААЛТ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хурийтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Хүлээн авах байгууллагын нэр
1	Амраптын байр-3	1/1/2015	М.кв	1211	799,925,000.00	6,642,925.31	793,282,074.69	“Монголпросцветмет” ТӨҮГ
2	Амраптын байр-4	1/1/2015	М.кв	1084	799,925,000.00	6,642,925.24	793,282,074.76	“Монголпросцветмет” ТӨҮГ
3	Оффисын барилга-3	1/1/2015	М.кв	489	295,373,000.00	2,452,905.89	292,920,094.11	“Монголпросцветмет” ТӨҮГ
4	Лабораторийн барилга	1/1/2015	М.кв	280	173,847,000.00	1,443,701.12	172,403,298.88	“Монголпросцветмет” ТӨҮГ
5	Агуулажын барилга/ жижиг/	1/1/2015	М.кв	75.6	32,857,000.00	272,858.82	32,584,141.18	“Тавантолгой тулш” ХХК
Нийт дүн								
						2,101,927,000.00 (хоёр тэрбум нэг зуун нэгэн сая есэн зуун хорин долгоон мянга)	17,455,316.38 (арван долзоон сая дөрвөн зуун тавин таван мянга гурван зуун арван зургаан төгрөг гучин найман мөнгө)	2,084,471,683.62 (хоёр тэрбум наян дөрвөн сая дөрвөн зуун далан нэгэн мянга зургаан зуун наян гурван төгрөг жаран хоёр мөнгө)